

Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай

ГЭРЭЭ

№АӨҮА-2012/05

Ерөнхий зүйл

Нэг талаас Ашигт малтмалын газар (цаашид АМГ гэнэ), нөгөө талаас 10444Х тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч Улаанбаатар хотын Хан-уул дүүргийн Татварын албанд 9011156137 тоот улсын бүртгэлтэй, аж ахуйн нэгжийн 5239168 тоот регистрийн дугаартай “Монголметал майнинг” ХХК (цаашид компани гэнэ) нь Ашигт малтмалын тухай хуулийн 23-р зүйлийн заалтыг үндэслэн Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Худаг байшинтын төмрийн хүдрийн орд дээр ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үед хийгдэх үндсэн ажлуудын хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх үе шат, хүлээх хариуцлагыг харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэгдүгээр зүйл. Гэрээний нөхцөл, хугацаа

1. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараахь ажлуудыг хийж гүйцэтгэнэ. **Үүнд:**

а. Гүйцээх хайгуулын ажлыг гүйцэтгэх.

б. Гидрогеологийн судалгаа хийх.

в. Нарийвчилсан геофизикийн судалгааны ажлыг гүйцэтгэх.

2. Гүйцээх хайгуулын ажлын үр дүнгийн тайланг боловсруулж, 2015 оны 01-р сарын 25 -ны дотор АМГ-т хүргүүлж, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх.

3. Гидрогеологийн судалгааг гүйцэтгэх хугацаа 2 жил байна.

4. Нарийвчилсан геофизикийн судалгааны ажлыг гүйцэтгэх хугацаа 2 жил байна.

5. Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Худаг байшинтын төмрийн хүдрийн ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааг 2015 оны 02 дүгээр сарын 28-нд дуусгавар болгоно.



Handwritten signature in blue ink.


ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

Хоёрдугаар зүйл. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

1. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн эрэл, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлын зардлыг улсын төсөвт төлөх гэрээг орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл хийхээс өмнө засгийн газрын 2007 оны 81 тоот тогтоолоор батлагдсан журмын дагуу байгуулсан байна.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч ашиглалтын өмнөх үйл ажиллагааны үе шатанд ашиглалтын үед хийж гүйцэтгэх ажлын зөвшөөрлийг авсан байна. Үүнд:
 - а. Газар, усны гэрээг байгуулах.
 - б. Байгаль ерөнхий орчны үнэлгээ / БОАЖЯ /
3. Орд ашиглах, эрдсийг баяжуулах, боловсруулах үед хэрэглэгдэх химийн бодис ашиглах зөвшөөрлийг авсан байна. Үүнд:
 - а.
 - б.
4. Гэрээний биелэлтийн тайланг гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 жил тутам АМГ-т ирүүлнэ.
5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээний биелэлтийн талаар болон ашиглалтын өмнөх үйл ажиллагааны явцын тухай мэдээллийг АМГ шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бичгээр мэдэгдэх ба тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуг мөн бичгээр хүсэлтэд заасан хугацаанд ирүүлнэ.
6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний биелэлтэй холбоотойгоор АМГ-аас хяналт, шалгалт хийж байгаа төлөөлөгчдөд холбогдох баримт, бичгүүдтэй танилцах боломж олгон, үйлдвэрийн талбайд саадгүй нэвтрүүлнэ.
7. Гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтээ АМГ-т бичгээр гаргаж болно.
8. Орд ашиглахтай холбогдсон бичиг баримтыг Монгол хэл дээр үйлдсэн байна.
9. Энэхүү гэрээг гэрээнд заасан нөхцлөөс өөр хэлбэрээр ашиглахыг хориглоно.

Гуравдугаар зүйл. Ашигт малтмалын газрын эрх, үүрэг

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний биелэлтийн талаар болон ашиглалтын өмнөх үйл ажиллагааны явцын тухай мэдээлэл авах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ тухай бичгээр хүргүүлнэ.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гэрээний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хүсэлтийг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор хариуг бичгээр хүргүүлнэ.

ЭХ СУРВАЛЖ  WWW.ILTODGEREE.MN

ААТАР Х
МОНГОЛ
МАЙН
ХХК
194.т.523

3. Энэхүү гэрээний заалтуудад өөрчлөлт оруулах тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн саналыг авсан байна.

4. Гэрээний заалтуудын биелэлтэнд хяналт, шалгалт хийх хүсэлтээ бичгээр хүргүүлнэ.

Дөрөвдүгээр зүйл. Бусад зүйл

1. Энэхүү гэрээнд АМГ болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчид гарын үсэг зурсан өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү гэрээний биелэлтийг ордыг ашиглалтанд хүлээн авсан комиссын дүгнэлт (гэрээний заалтууд бүрэн биелүүлсэн акт)-ийн тухай АМГ-ын шийдвэр гарсаны дараа хамтран дүгнэж акт үйлдэнэ.

3. Гэрээг 3 хувь үйлдсэн бөгөөд нэг хувийг АМГ-ын Уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын нэгжид, нэг хувийг тусгай зөвшөөрөл эзэмшигч, нэг хувийг кадастрын бүртгэлийн төвийн архивт тус тус хадгална.

4. Энэхүү гэрээний биелэлттэй холбоотой гарах аливаа маргааныг гэрээлэгч талууд харилцан тохирч шийдэх бөгөөд эс шийдэлд хүрсэн тохиолдолд Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээ байгуулсан:

Ашигт малтмалын газрыг төлөөлж:
Уул уурхай, судалгааны хэлтсийн дарга



.../Ц.Даваацэрэн/

Танилцсан: ТБОТ-ийн дарга

Боловсруулсан: ТБОТ-ийн мэргэжилтэн

Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:
“Монголметал майнинг” ХХК -ийн захирал



.../Ц.Батсайхан/

Б.Элбэгзаяа

Т.Буянбат

2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот.

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГЭРЭЭНД ОРУУЛАХ НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

2014 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасны дагуу шинэчлэн бүртгэл хийгдэж байгаатай холбогдуулан нэг талаас Ашигт малтмалын газар /цаашид АМГ гэх/, нөгөө талаас Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Худаг байшинтын төмрийн ордын XV-010444 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн эзэмшигч “Монголметалл майнинг” /Фокус металл майнинг/ ХХК-тай байгуулсан №АӨҮАГ-2012/05 тоот гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулав.

Энэхүү нэмэлт өөрчлөлт оруулсан хавсралт нь үндсэн (№АӨҮАГ-2012/05) тоот гэрээний салшгүй хэсэг байна.

1 Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Худаг байшинтын төмрийн ордын талбайн ашигт малтмалын хайгуулын XV-010444 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа 2015 оны 02 дугаар сарын 28-ны өдөр дуусгавар болно.

2. Тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрийг үндсэн гэрээ байгуулах үед мөрдөж байсан хуулийн дагуу төлөх буюу төлбөрийн хэмжээ 1 гектар тутамд 1.5 америк доллар байна.


3. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай гэрээнд Ашигт малтмалын тухай хуулийн 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдөр орсон нэмэлт өөрчлөлтийг мөрдөж ажиллана.

4. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээнд оруулах энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө баталгаажуулж, тусгай зөвшөөрлийн хавсралтанд шинэчлэн бүртгүүлсэн тухай тэмдэглэгээ хийлгэнэ.

Ашигт малтмалын газрыг төлөөлж:

Уул уурхайн хэлтсийн дарга


..... С.Баттулга



Тусгай зөвшөөрөл эзэмшигчийг төлөөлж:

“Фокус металл майнинг” ХХК-ийн захирал

..... Ц.Батсайхан





Хайгуулын тусгай зөвшөөрөл:

Эзэмшигч:	Фокусметал майнинг	Олгосон огноо:	2003.04.16
Талбайн нэр:	Худаг байшинт	Дуусах огноо:	2015.02.28
Талбайн хэмжээ:	378.44 Га	Барьцаалсан байдал:	---
Байршил:	Булган (Бүрэгхангай)	Шүүхэд хэлэлцэгдэж буй эсэх:	---
Ашигт малтмал:	---	Планшетын дугаар:	M-48-137

Хөдөлгөөн:

Код	Төрөл	Бүртгэсэн огноо	Одоогийн байдал
XV-010444-000-CI	[CI] Цэгцлэгдсэн өгөгдөл	2010.02.09	47-Албадан хийсэн хөдөлгөөнийг эцэслэх
XV-010444-009-NMR	[NMR] Шинэ ашиглалтын тусгай зөвшөөрлөөс үүдэж багасах	2006.11.29	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-010-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2010.04.20	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-011-TF	[TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх эзэмшигч: Эс Жи групп)	2010.08.16	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-012-EE	[EE] Хайгуулыг тусгай зөвшөөрлийг сунгах	2011.04.25	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-013-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2011.04.29	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-014-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2012.03.27	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-015-AP	[AP] Ашиглалтын өмнөх үйл ажиллагаа	2012.02.29	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-016-TF	[TF] Бүхэлд нь шилжүүлэх (Өмнөх эзэмшигч: Монголметал майнинг)	2012.05.16	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-017-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2013.04.10	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-018-FE	[FE] Тусгай зөвшөөрлийн жилийн төлбөр	2014.04.07	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-019-AP	[AP] Ашиглалтын өмнөх үйл ажиллагаа	2014.12.03	19-Батлагдсан өргөдлийг эцэсл
XV-010444-020-EX	[EX] Хугацаа дуусах (дуусгавар болгох)	2015.03.16	47-Албадан хийсэн хөдөлгөөнийг эцэслэх

Эзэмшигчийн бүртгэл:

Нэр:	Фокусметал майнинг	Утас:	328408, 70123960
Аж ахуйн нэгжийн төрөл:	гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай	Гар утас:	99118743, 9919050732
Бүртгэлийн дугаар:	5567319	Факс:	328408, 70122639
Улсын бүртгэлийн дугаар #:	9019064099		



Ашигт малтмалын газрын
Кадастрын хэлтэс

Тусгай зөвшөөрлийн
дэлгэрэнгүй мэдээлэл
ТЗ-ийн дугаар: ХВ-010444

Улс: Хонг-Конг Е-мэйл: ts.bn2009@yahoo.com

Захирлын овог, нэр Zhou Xucheng Zhou Xucheng

Эзэмшигчийн хаяг:

Гудамж: Моннис-2 байр 9 давхарт Шуудангийн хайрцаг: ---
Хот: Улаанбаатар ZIP код: ---
Аймаг/ Хот: Улаанбаатар
Сум/ Дүүрэг: Хан-Уул
Баг/ Хороо: 15-р хороо


ТЗ-ийн солбицол:

Олон өнцөгт	#	Уртраг			Өргөрөг		
		град	мин	сек	град	мин	сек
Ex1	1	104	16	0.94	48	19	1.82
Ex1	2	104	16	0.93	48	17	1.82
Ex1	3	104	15	0.93	48	17	1.82
Ex1	4	104	15	0.94	48	18	26.81
Ex1	5	104	15	50.94	48	18	26.81
Ex1	6	104	15	50.94	48	18	51.82
Ex1	7	104	15	0.94	48	18	51.82
Ex1	8	104	15	0.94	48	19	1.82

АШИГЛАЛТЫН ӨМНӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ
ДУУСГАВАР БОЛСОН ТУХАЙ АКТ № 2015/04

Нэг талаас АМГ, нөгөө талаас Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Худаг байшинтын төмрийн хүдрийн ордын XV-010444 тоот хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Монголметал майнинг” ХХК-тай харилцан тохиролцож 2012 оны 02 дугаар сарын 29-ны өдөр байгуулсан №АӨҮА-2012/05 тоот гэрээний үйлчлэх хугацаа дууссан тул Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах журмын 6.1.3-д заасны дагуу ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээг дуусгавар болгов.

Жич: АМГ-ын Кадастрын хэлтсийн CMCS программаас ХВ-010444 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй мэдээллийг хуулбарлан хавсаргав.

УУЛ УУРХАЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  С.БАТТУЛГА


2015 оны 03 дугаар сарын 19-ний өдөр